



ШААМАР СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022-04-30 № 107-2022/04-НА-78  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Шаамар сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Шаамар сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020531

## Дүгнэлт

Шаамар сумын Монгол Ардын намын хорооны Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Шаамар сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр 1.3 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Шаамар сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНООС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**“ХАМТАРЧ ШИЙДЬЕ - ХӨГЖИН ДЭВШЬЕ”**

Сум, тосгоноо хөгжүүлж, үйлдвэрлэлээ дэмжиж, ажлын байраа нэмэгдүүлж, өрх бүрийн амьдрал дээшлэхэд зориулсан бодлоготой ажиллана.

**Нэгдүгээр бүлэг: ИРГЭНЭЭ ДЭМЖИХ ТАЛААР:**

1.1. Сум орон нутгийн онцлогт нийцсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, дэвшилттэй техник технологийг нэвтрүүлэхэд тусалж дэмжиж ажиллана.

1.2. Орон нутагт жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний газар байгуулах замаар 30-өөс доошгүй байнгын ажлын байр бий болгоно.

1.3. Сумын төвөөс алслагдмал ажиллаж амьдарч байгаа иргэддээ төрийн үйлчилгээг ойртуулан иргэдийг зардал чирэгдлийг багасгах зорилгоор баг бүрд өдөрлөг, ЗДТГ-ын “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР” арга хэмжээг жил бүр зохион байгуулж ажиллана.

1.4. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй зарим иргэдийг орон байраар хангах ажлыг сум, тосгонд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

1.5. Иргэддээ мэргэжлийн болон шаардлагатай сургалтыг зохион байгуулж мэргэжлийн багш нарыг урьж ажиллуулах.

1.6. “Сум хөгжүүлэх сан”-гаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

1.7. Иргэдийн чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх, эрүүл чийрэг болгох зорилгоор спортын олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

1.8. Сум, аймгийнхаа нэрийг олон улсад болон Монгол улсад өндөрт гаргаж байгаа иргэдээ тал бүрээр дэмжиж хамтран ажиллана.

1.9. Суманд авто спортоор хичээллэх хүсэл сонирхолтой залуучуудыг дэмжиж зохион байгуулан аймгийн “АММС холбоо”-той хамтарч ажиллана.

1.10. Жил болгон “ӨРГӨН-СЭЛЭНГЭ” амьд хөгжмийн наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтарч ажиллана.

**Хоёрдугаар бүлэг: БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

2.1. Дулаанхаан тосгоны ЕБС-ийн өргөтгөлийн ажлыг холбогдох газруудад хандан шийдвэрлүүлнэ.

2.2. Олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцсон багш, сурагчдыг дэмжиж ажиллана.

2.3. Сум, тосгоны ЕБС-ийн сурагчдын дунд хоёр жил тутамд “ХҮҮХДИЙН ЧУУЛГАН”-ыг өргөн цар хүрээтэй зохион байгуулж чуулганаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

2.4. Сумын ЕБС-ийг мэдээлэл зүйн кабинеттай болоход дэмжлэг үзүүлнэ.

**Гуравдугаар бүлэг: ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

3.1. Сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийхэд шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, авто машинаар хангуулах ажлыг салбарын яам болон төсөл хөтөлбөр, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын дэмжлэг тусламжтайгаар шийдвэрлэнэ.

3.2. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамааруулах ажлыг тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнтэй хамтран зохион байгуулна.

3.3. Сум, тосгоны эмч, эмнэлгийн ажилтнуудыг дахин мэргэшүүлэх, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэхэд зориулж сургалтад хамруулж ажиллана.

3.4. Физик эмчилгээний болон уламжлалт эмчилгээний кабинетыг нээн ажиллуулж техник тоног төхөөрөмжөөр хангана.

3.5. Эрүүл мэндийн төвийн 2-р байранд их засвар оруулах ажлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

#### **Дөрөвдүгээр бүлэг: ДЭД БҮТЭЦ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

4.1. Дэлгэрхаан 1-р багийн ЖИМС НОГОО, ТӨМӨР ЗАМЫН 34-р км-ын ЗОГСООЛ хүртэл 3.5 км сайжруулсан зам тавих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.2. Дэлгэрхаан 1-р багийн ТӨМӨР ЗАМЫН 49-р ӨРТӨӨ хүртэл 6 км сайжруулсан зам тавих ажлын ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.3. Охиндий 2-р багийн байр, 2-р цэцэрлэгийн урд автомашины зогсоол барих болон зам тавих ажлыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.4. Дэлгэрхаан 1-р багийн 5-н толгой, Охиндийн 2-р багийн 1-р хэсгийн дунд гүний худаг гаргаж цэвэр усны хангамжийг нэмэгдүүлнэ.

4.5. Дэнжийн төвийн худагт их засвар хийж, ухаалаг тоолууртай болгоно.

4.6. Сумын төвөөс алслагдсан хэсгүүд дээр ЖИМС НОГОО, 49-р ӨРТӨӨ, НАРСАН СҮҮЛ-д төрийн болон бусад үйлчилгээ явуулах байрыг аймгийн дэмжлэгээр барьж байгуулах ажлыг уламжилж, шийдвэрлүүлнэ.

4.7. Дулаанхаан тосгонд хүүхэд залуучуудын чөлөөт цагтаа тоглож байх орчин үеийн тоглоомын талбайг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.8. Дулаанхаан тосгоны Соёлын төвийн их засварыг холбогдох дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.9. Дэлгэрхаан 1-р багийн хүүхдийн тоглоомын талбайн хажууд "Гэрэлт гудамж"-ийг аж ахуйн нэгж байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлнэ.

4.10. Шаамар сумаас Ардын хувьсгалд оролцсон журамт цэргүүдийн дурсгалд зориулж "Партизан цэргүүдийн хөшөө" цогцолборыг аж ахуйн нэгж байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлнэ.

4.11. Охиндий 2-р багийн Бүүргийн 1-р хэсгийн цахилгааны хангамжийг холбогдох дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.12. Охиндий 2-р багийн Бүүргийн 1-р хэсэгт ундны цэвэр усаар хангах зорилгоор гүний худгийг барьж байгуулах ажлыг холбогдох дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.13. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд зориулж сум болон Дулаанхаан тосгоны дөрвөн замд камер суурилуулна.

#### **Тавдугаар бүлэг: ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ӨРХИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДЭЭ ДЭМЖИХ ТАЛААР:**

5.1. Төмс хүнсний ногоо тариалагч, малчин, зөгийчин иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг төв суурин газрууд болон зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүний дэмжлэг туслалцааг авч ажиллана.

5.2. Туслах аж ахуй эрхэлдэг өрхөд шаардлагатай үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

5.3. Төмс, хүнсний ногоо тариалагчдад зориулж "ЗООРЬ ХӨТӨЛБӨР"-ийг олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.4. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар малчин өрхийг дэмжиж ашиг шим ихтэй сайн үүлдрийн малыг хөгжүүлэх сүргийн зүй зохистой бүтцийг бий болгон мал аж ахуйг өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.5. Малчин өрхүүдээс гарч байгаа санал санаачилгыг дэмжиж сум орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран сүү борлуулах бэрхшээлийг шийдвэрлэж ажиллана.

5.6. Мал эмнэлгийн үйлчилгээний ажлыг чанаржуулж малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ариун цэвэр, ариутгал халдваргүйжүүлэлтийг чанартай хийлгэж МАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд анхаарна.

5.7. Хүнсний ногоо тариалагч өрхийг дэмжиж хамгаалагдсан хөрсөнд тариалах тариалалтыг өргөжүүлэх зорилгоор хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн тоог иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор нэмэгдүүлж ажиллана.

5.8. Шаамар суманд зөгийн бүтээгдэхүүнийг савлах, сэмж хийх үйлдвэр байгуулах ажлыг олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтарч зохион байгуулна.

#### **Зургаадугаар бүлэг: БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

6.1. Сум, тосгоны хэмжээнд Ойн нөхөн сэргээлтийн ажлыг тогтмол хийж, жил болгон ногоон бүсийг нэмэгдүүлж мэргэжлийн байгууллага болон иргэдтэйгээ хамтран хэрэгжүүлнэ.

6.2. "ЦЭВЭР ОРЧИН БИДНИЙ АМЬДРАЛД" аян жил болгон зохион байгуулж хоггүй сум, тосгон болж ажиллана.

6.3. Дулаанхаан тосгоны төв зам дагуу мод тарих, хашаажуулах, тохижуулах ажлыг иргэд, аж ахуйн нэгжийн дэмжлэгтэйгээр бий болгоно.

6.4. Сумын хэмжээнд өрх бүр, аж ахуйн нэгж, албан байгууллагууд өөрийн эзэмшил газартаа олон төрлийн мод тариалж ногоон хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлсэн иргэдийг дэмжиж ажиллана.

6.5. Дулаанхаан уулын рашааны ам, Далий ягаан цэцэг ургадаг орчин зэрэг үзэсгэлэнт газруудыг аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх боломжийг бий болгож, эдийн засгийн эргэлтэд оруулж шинэ ажлын байр нэмэгдүүлэх ажлыг аж ахуйн нэгжийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

6.6. Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн хариуцлагыг нэмэгдүүлж байгальд учрах хохирлоос урьдчилан сэргийлж ажиллана.

6.7. Сумын хэмжээнд түгээмэл тархацтай байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг аймгийн Байгаль орчны алба, мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

6.8. Жил болгон ой хээрийн түймэр, бусад аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж сургалт, сурталчилгааг иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагуудын дунд аймгийн Онцгой байдлын газар, Тужийн нарсны байгалийн цогцолбор газар зэрэг байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Сумын МАН-ын хороо

